

МӨРДӨХ АЛБАНЫ ҮҮСЭЛ, ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ БА МӨРДӨН ШАЛГАХ АЛБАНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ

Д.Бямбабат

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8021 дамжааны
суралцагч, цагдаагийн хошууч

Товч агуулга. Хүн төрөлхтний үүсэл, хөгжлийн түүхэн үйл явц, ангийн тэмцлийн үр дүнд улс, гүрэн байгуулагдаж, улсаа дагаж төр оршин тогтнож, улмаар төрт ёсны үйл хэргийг нэг мөр даган хэрэгжүүлэх зайлшгүй хэрэгцээ, шаардлагын үүднээс хууль тогтоомжууд бий болон хөгжлийн явцад нийгмийн янз бүрийн тогтолцоог дамжин, өнөөдрийн ардчилсан нийгмийг хүртэл өөрийн бодит үүргээ биелүүлж ирсэн түүхтэй.

Түүхийн энэхүү хөгжлийн бүхий л үе шатанд дэлхийн улс, гүрнүүд гэмт хэрэг, түүний шалтгаан нөхцлийг олж тогтоох, гэмт этгээдийн хувийн шинж байдал, онцлогийг судлахад чиглэсэн судалгааг тасралтгүй явуулж ирсэн нь одоогийн гэмт хэрэгтэй тэмцэх, илрүүлэх, мөрдөн шалгах, нотлоход чиглэсэн орчин үеийн салбар шинжлэх ухааны хөгжлийг тодорхойлж, улмаар мэдлэгийн тусгай салбар криминологи, криминалистик, эрүүгийн эрх зүй, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй зэрэг салбар шинжлэх ухааны онолын үндэс суурийг бий болгож мөрдөн шалгах ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын ойлголт хөгжиж ирсэн түүхтэй.

Энэхүү өгүүллээр мөрдөх алба үүсэн байгуулагдсан түүхэн уламжлалыг гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, мөрдөн шалгах ажиллагаа, түүний удирдлагын эрх зүйн зохицуулалт нь хэрхэн хувьсан өөрчлөгдсөнийг судлахыг зорьсон.

Abstract:

As a result of the historical process of the origin and development of mankind, and as a result of the class struggle, states and empires were established, and the state followed the state, and then, in view of the necessity and requirement to implement state affairs in a single line, laws were created and through various social systems in the course of development, even today's democratic society has a history of fulfilling its real obligations.

At all stages of this development of history, countries and powers of the world have continuously conducted research aimed at identifying crimes and their causes, investigating the personality and characteristics of criminals, which is aimed at combating, detecting, investigating and proving current crimes. It has a history of determining the development of modern branch of science, and then creating the theoretical foundations of branches of science such as criminology, criminalistics, criminal law, criminal law, and the management and organization of investigations.

This article aims to study the historical tradition of the establishment of the investigation service, the fight against crime and violations, and how the legal regulation of its management has evolved.

Түлхүүр үг: Мөрдөх алба, түүх, уламжлал.

Keywords: Detectives, history and tradition.

Үндсэн хэсэг

Гэмт хэргийг илрүүлэх, нотлох мөрдөх шалгах, түүний удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагааг зохицуулж буй дэлхийн олон орны болон Монгол Улсын хууль тогтоомжийн үүсэл, хөгжлийг судлан дүгнэхэд бүхэлдээ хөгжлийн нийтлэг зүй тогтлыг илэрхийлж байгаа хэдий ч онолын чиг баримжаа өөр, өөрийн үзэл баримтлал, хөгжлийн чиг хандлага, хууль боловсруулах үйл ажиллагаанд бусад орны зүгээс үзүүлсэн нөлөө, гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн үр нөлөөтэй арга, эрх зүйн орчиныг бий болгоход бусад орны тэргүүн туршлагыг судлах, нэвтрүүлэх гэх мэт олон хүчин зүйлийн нөлөөллөөр өөр өөрийн хөгжлийн хэв загвараа олсоор иржээ¹.

Монголын эртний улсын түүхээс үзэхэд хүннү гүрний үед Шаньюйн овгийнхон гэмтнийг байцааж, нүүдлийн маягийн амьдралд нийцүүлэн аль болох бага хугацаанд байцааж, хорихыг 10 хоногоос хэтрүүлэхгүйгээр шийдвэрлэх эрхтэй байснаас дүгнэхэд мөрдөн шалгах ажиллагааг тухайлан шийдвэрлэдэг хүмүүстэй болж гэмтнийг тодорхой хугацаанд байцааж, хэргийг шийдвэрлэж эхэлсэн болох нь харагдаж байна².

Мөн хууль тогтоомжийн үүсэл хөгжлийн нийтлэг зүй тогтоолоос гадна улс, гүрэн бүрийн үндэсний онцлог, гэмт хэргийг ойлгож танин мэдэх, гэмт хэрэгтэй тэмцэхэд нийгэм, эдийн засаг, улс, төр соёлын хөгжлийн бүхэл бүтэн системийн нөлөөлөл байсныг үгүйсгэж болохгүй.

Түүхийн эх сурвалжуудаас дүгнэхэд Монгол Улс төр, хууль цаазын 2000 гаруй жилийн түүхэн уламжлалтай бөгөөд монгол орны газар нутагт анхлан оршин сууж байсан эртний улсууд болох Хүннү, Сяньби, Нирун, Түрэг, Уйгар, Кидан зэрэг улс гүрнүүд маш хатуу, чанга хуулийг боловсруулан гаргаж цэрэг дайны болон засаг захиргааны удирдлага, иргэний эрх зүйн харилцаа, хэрэг зөрчлийг нотлох шийдвэрлэх үйл ажиллагааг удирдах, чиглүүлэх харилцааг хүртэл зохицуулж байжээ.

Тухайлбал, Хүннү гүрний хаан Модун-Шаньюй түмэтийн даргыг томилон удирдлагын зохион байгуулалтыг хэрэгжүүлдэг байсан бөгөөд түмэтийн дарга цэрэг, засаг захиргаа, аж ахуй удирдлагыг хэрэгжүүлэхээс гадна хэрэг зөрчлийг шийдвэрлэх эрхтэй байжээ.

¹ www.legalingo.mn // татаж үзсэн: 04.12.2024.

² В.В Таскин Үндэстэн улс бүрийн тухай тэмдэглэл:эмхэтгэл 17 дахь тал, 40 дэх тал

Харин Нирун улсын үед нүүдэлчдийн урьд өмнө баримталж байсан аравтын тогтолцоонд улсаа оруулж цэрэг, захиргааны шинжтэй олон хуулиудыг батлан гаргасан ба анх удаа “Төрийн шүүгч” гэж албан тушаалтныг томилон түүнд хэрэг, зөрчлийг хянан шийдвэрлэж байх эрхийг олгосон байна.

Монголын хууль цаазын гол эх сурвалжид зүй ёсоор тооцогддог анхны бичмэл хууль бол 1206 онд Чингис хааны зарлигаар батлагдсан түүний шадар түшмэл Шихихутагийн гаргасан “Их Засаг” хэмээх хууль юм.

Монголын нууц товчоонд тэмдэглэгдсэн хууль зүйн шинжтэй баримтаас үзэхэд 1206 онд Чингис хаан улсын заргач ноён Шихихутагт “Чи миний үзэх нүд, сонсох чих явтугай. Улсын хулгайг цээрлэх, худлыг цагаатгах, үхүүлэх ёстойг үхүүлж, яллах ёстойг яллатугай. Нийт өмчийг хувааж заргыг шийтгэ¹ хэмээн зарлиг буулгаж түүнийг “улсын заргач” болгож гэмтнийг байцааж, шийтгэх эрхийг олгосон байна. Улсын заргач ноён Шихихутаг бүх улс, иргэний хувь хувилсан зарга шийтгэснээ “хөх дэвтэрт” тэмдэглэн бичиж тэмдэглэх үүргийг хүлээж байв.

Шихихутаг “Их засаг” улс бүрийн зохиосон төдийгүй улсын заргачаар олон жил ажилласан. XIII

зууны Монгол төрийн зүтгэлтний дотроос хамгийн өндөр боловсролтой, хэрэгтнийг байцаан, гэм бурууг тогтоож, ял шийтгэл оногдуулах туршлагатай, нигүүлсэнгүй түшээ байсан ажээ².

Энэ үеэс Их засаг хуульд заасны дагуу онц, аюултай хэрэгтнийг хаан улсын их заргачид өргөн мэдүүлж, хэргийн бодит үнэнийг олох, мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааг явуулж байсныг нотолж байна³.

Өнөө хүртэл уламжлагдан судлагдаж ирсэн түүхийн янз бүрийн гар бичмэл эх сурвалжаас харахад “Их Засаг” хууль Их Монгол Улсын хааны бүрэн эрх, засаг захиргаа, цэрэг, гадаад харилцаа, ахуй заншил, иргэд хоорондын болон гэр бүлийн харилцаа, сургаал, сургамж, тэтгэвэр, тэтгэмж, өмч хөрөнгө, өв залгамжлал, шашин шүтлэг, худалдаа арилжаа, татвар, гэмт хэрэг, ялын бодлого, шүүн таслах журам зэрэг нийгмийн бүхий л харилцааг зохицуулсан хууль байсан.

“Их Засаг” хуулийн өмнө энгийн ард иргэд болох ихэс дээдэс тэгш эрхтэй байж, адил ял зэмлэл хүлээдэг байснаараа онцлог юм. Үүний тод илрэл “Их засаг” хуулийн 22 дугаар зурваст “Хүн бүрийн адил тэгш эрх, баян ядуу, эрхэм доорд хэмээн ялгаж үл болно” хэмээн заасан нь нэг талаас монголын хууль цаазын эх сурвалжийн

¹ Монголын нууц товчоо-УБ., 1990. 180 дахь тал

² И.Дашням Монгол Улсын төр, эрх зүйн түүх тэргүүн боть -УБ., 2005,376 дахь тал

³ Мөрдөн байцаах газар. Монгол улсын цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албаны түүхэн замнал. Мөрдөн байцаах албаны 65 жилийн ойд зориулав.-УБ 2011.5 дахь тал

анхдагч энэ хуулийн ач холбогдлыг өндөрт өргөж байгаа төдийгүй, нөгөө талаас төрийн зүгээс ард түмнээ ялгаварлахгүй тэгш хандах ёстой гэсэн санааг олон зууны тэртээх хууль цаазын бичигт тунхагласан нь гайхамшигтай юм. Хуулийн ял шийтгэл нь маш хатуу байсан бөгөөд дайнд явах үед урд яваа хүнийхээ санамсаргүй унагаасан зүйлийг арын хүн авч өгөхгүй бол цаазаар авах, ард иргэдийн доторх хулгай дээрмийг чандлан хорьж зөрчигдсийг хатуу шийтгэх ялыг тус тус оноодог байжээ.

“Их засаг” хууль бол Их Монгол улсын тулгар төр байгуулагдсан түүхт үйл явдлын үр дагавар болон батлагдсан бөгөөд “Засаг” гэдэг үгийн эртний язгуур утга нь хууль цааз, дүрэм, журам, хэв ёс гэсэн ойлголтыг илэрхийлж байсан.

Судлаачид “Их засаг” хуулийг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээ талаас судалсан нь цөөнгүй ба гэмт хэргийн нотлох, мөрдөн шалгахад чиглэсэн буюу процессын эрх зүйн талаас нь дүгнэж төдийлөн судлаагүй харин профессор Г.Совд “Их Засаг” хуулийн хэм хэмжээ буюу хэргийг нотлох, шалгаж тогтооход чиглэсэн хэм хэмжээ эзэлдэг гэж анх удаа тодорхойлон дүгнэсэн байна¹.

Дараагийн хууль бол 16 дугаар зууны сүүлч 17 дугаар зууны эхэн үед хойд монголын хаадын их чуулганаар батлан гаргасан “Халхын шинэ олдсон цааз эрхэмжийн дурсгалт бичиг” уг хуулиар иргэний болон гэмт хэрэг,

зөрчлийг шалгах явцад үүссэн маргаан, түүнийг хэрхэн шалгаж, шийдвэрлэхийг удирдан чиглүүлэх, улмаар хянах харилцааг зохицуулж байжээ.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэх гол оролцогчдын нэг нь “элч” байсан ба гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдийг хошуу ноёнд хүргэх, хэрэг зөрчлийг хянан шалгах эрхийг олгосон байна.

Энэ хуулиар гэмт хэрэг, зөрчлийг шалгаж шийдвэрлэх, гэм бурууг хянан тогтоож ял шийтгэл оногдуулахад гэрчийн мэдүүлэг маш чухал үүрэгтэй болохыг заагаад гэрч нь онцгой үүрэг бүхий оролцогч болохыг тогтоож өгсөн байна. Жишээлбэл: Гэрчийг мэдүүлэг өгсний төлөө есөн бог малаар урамшуулах (1 хууль 76 дугаар заалт), түүнчлэн зуун толгой малаас таван толгой малыг өөрийн хүнс хэрэгцээндээ хэрэглэхэд олгож (8 хууль 6 дугаар заалт) байхаар тусгасан, мөн гэрч худлаа мэдүүлэг өгвөл есөн богоор торгох (2 дугаар хууль, 3 дугаар заалт), гэрчийн амь насыг хохироон алсан бол 5 тэмээ 15 адуугаар торгож (8 дугаар хууль, 3 дугаар заалт) байх заалтууд тусгагдсан байдаг.

Маргаантай хэргийг түшмэлүүд шийдвэрлэдэг байсан ба хэрэг маргааныг тодорхой газар нутагт явуулах товыг гаргаж маргалдагч талуудыг байлцуулан шийдвэрлэдэг байжээ. Хэргийн үнэн зөвийг олж тогтоон шалгах, орчин үеийнхээр бол хэргийг нотлох, мөрдөн шалгах болон

¹ Г.Совд БНМАУ-ын Эрүүгийн эрхийн курс.- УБ., 1973. 28 дахь тал

хэргийг шийдвэрлэснийхээ төлөө түшмэлд 1 толгой малаар урамшуулдаг байсан байна.

Аливаа хэрэг маргааныг шалгаж шийдвэрлэсний дараа хяналт, шалгалтыг явуулж, хэрэв хэргийг шалгах ажиллагаанд хууль зөрчсөн, шийтгэлийг буруу оногдуулсан байдал гаргавал түшмэлийг 5 толгой тэмээгээр торгох шийтгэл оногдуулдаг байсан ба ийм зөрчил гаргасан түшмэлийг зөвхөн торгоод зогсохгүй үүрэгт ажлаас нь чөлөөлдөг байжээ.

Монголын эрх зүйн түүхэн баримт бичгийн нэг бол 1640 онд Монгол Ойрадын ноёдын чуулганаар батлан гаргасан “Их цааз” бичиг бөгөөд энэ хуулийн гол зорилго нь Монгол-Ойрадын ноёдын эвдрэл, хямралдааныг таслан зогсоох хэрэг зөрчил, иргэний болон захиргааны харилцааг зохицуулсан, ард иргэдэд ялгаварлахгүй тэгш байх талаар тусгасан байна. Хуулийн зохицуулалтын харилцаа нь гэмт хэрэг, зөрчил иргэний хэрэг маргаан, хэрэг зөрчлийг хянан шалгах, шийдвэрлэхэд чиглэж байсан бөгөөд үүнийг бүх шатны түшмэлүүд, элч нарын үүрэг оролцоотойгоор хэрэгжүүлж байсан. Мөн “Монгол ойрадын их цааз хууль”-д гэмт хэргийн төрлийг тодорхойлох оролдлогыг анх удаа хийж, хууль цаазын зүйлчлэлийн тухай ойлголтыг анх буй болгосон байна¹.

Манж чин улсын эрхшээлд байсан /1691-1911/ он жилүүдэд мөрдөн шалгах, гэм бурууг тогтоох, шүүн таслах ажиллагаа “Хүрээнд сууж, хэрэг шийдэх сайдын яам” гүйцэтгэдэг байжээ². Хэрэг заргыг хариуцаж байсан ноёд, түшмэдүүд хэрэг хүлээлгэхийн тулд, бусдын сэтгэл санаа, бие эрхтэн, амь насанд хохирол учруулж байсны жишээ нь есөн эрүү, шүүлт” байсан нь манжийн ноёрхлыг хэрэгжүүлэх харгислалын арга байсан. “Есөн эрүү шүүлт”-ийн хор уршгаар хэрэгт шалгагдсан сэжигтэн этгээдүүд бүх насаараа эрэмдэг болж үлддэг байжээ.

Манж улс Монголыг эрхшээлдээ бүрэн оруулах нэг арга нь Монголын хуулийг манжлах бодлого байсан ба үүний нэг жишээ нь 1626, 1638 онд зохиож 1695 онд хэвлэгдсэн бүгд 152 зүйл бүхий “Монгол цаазын бичиг”, 1789 онд зохиосон 209 зүйл бүхий “Хууль зүйлийн бичиг” хэмээх хуулийг дагаж мөрдүүлж эхэлсэн байна.

Монгол-Ойрадын хууль Монголын феодалын нийгмийн харилцааны эрх зүйг зохицуулахад чиглэгдэж байсан ба 1709 оны “Халх журам” хуулийг гарах хүртэл хэрэгжиж байсан.

Монголын хууль цаазын бичгийн шилдэг бүтээлийн нэг бол “Халх журам” хууль ба түүнийг гадаад, дотоодын олон эрдэмтэд судалсан ба судлаач С.Жалан-Аажив тусгайлан

¹ Т.Алтангэрэл. Монгол-Ойрадын их цааз түүний судалгаа-УБ., 1998.30 дахь тал

² Мөрдөн байцаах газар. Монгол Улсын цагдаагийн байгууллагын мөрдөн

байцаах албаны түүхэн замнал.Мөрдөн байцаах албаны 65 жилийн ойд зориулав.-УБ., 2011.5 дахь тал

судалж, хэд хэдэн бүтээл туурвисан байна. Тэрээр уг хуулийг “Монгол хууль цаазын дурсгалт бичиг төдийгүй шилдэг, дээд нь мөн” гэж дүгнэсэн байдаг. Халх журам бол монголын өөрийн жинхэнэ бодит ахуй амьдралаас ургуулан монгол сэтгэлгээгээр зохиож тусгаар тогтнол, төрт ёс, шашин шүтлэг, ард иргэдийн ялгаварлахгүй тэгш байдал, зан заншлаа хуульчлан баталсаныг гэрчлэх гайхамшигт баримт бичиг юм гэж үзсэн.

Энэ бүхнээс дүгнэхэд Чингис хааны “Их засаг” хуулиас эхлээд, “Халх журам” хүртэлх батлан гаргасан хуулиуд тухайн үедээ Монгол феодалын нийгмийн үеийн иргэний, эрүүгийн эрх зүй, гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, шийдвэрлэх, удирдан чиглүүлэх, харилцааг зохицуулж байсныг судалгааны явцад үзсэн бүтээлүүд гэрчилж байна.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор Ж.Долгорсүрэн цагдаагийн байгууллагын түүхэн хөгжил, замналыг дараах гурван үе шатанд ангилан авч үзсэнтэй уялдуулан эрх зүйн зохицуулалтыг түүхчлэн авч үзье¹.

1. Цагдан сэргийлэх байгууллагын үүсэл ба Богд хаант төрийн үеийн цагдан сэргийлэх байгууллага (1865-1921)

2. Ардын хувьсгал, хөрөнгөтний бус хөгжлийн болон социализм байгуулахаар замнасан үеийн төрийн цагдан сэргийлэх байгууллага (1921-1990)

3. Орчин үеийн (эрх зүйт төрийн) цагдаагийн байгууллага (1990 оноос хойш)

Манж Чин Улсын Эрхшээлд байх үед Ар Монголд “Цагдаа” гэдэг нэршил, алба анх бий болсон байна. Ар Монголд “цагдаа” гэдэг тусгай үүрэг гүйцэтгэдэг алба хаагч 1733 онд байгуулагдсан Улиастайн манж жанжны газрын мэдэлд “Улиастайн цагдаа цэрэг” нэртэйгээр анх бий болжээ.

Монгол цагдаа нь цагдаа цэргийн хэлбэрээр анх үүсэж, цэргийн болон харуулын, өртөөний албатай хавсарч, цагдаагийн үүргийг цэргүүд гүйцэтгэж байсан тул “цагдаа цэрэг” нэршил бий болжээ.

1846 онд Хүрээний манж сайдын яамнаас Хүрээг гэмт хэрэг, хэв журмын зөрчлөөс сэргийлэх зорилгоор дүрэм хэмжээ тогтоож, Хүрээний дотогш, гадагш хилийн дээсийг тогтоон, Түшээт хан, Сэцэн хан, Их шавиас түшмэл, зайсан, цэрэг, ард гарган халалцуулан цагдуулах болсон, 1866 онд Хүрээний хилийн дээсийг 15 газраар хэмжээлэн тогтоосныг Түшээт хан, Сэцэн хан, Их шавьд хувааж хариуцуулснаар “Арван тавны газрыг цагдах цагдаа” буюу “арван тавны цагдаа” гэдэг нэршил гарчээ. Хожим 1911 оноос хойш Хүрээний гадуурх 15 газрыг цагдан байцаах морьт цагдаа цэргийг арван тавны цагдаа, Хүрээний доторх гудамж, зээлийг цагдан байцаах, явган цагдаа цэргийг өмсөж байсан дүрэмт хантаазных нь өнгөөр

улаан ханжаарт цагдаа гэж ялган нэрлэж хэлэлцэх болжээ.

Манж Чин улсын “Шинэ засгийн бодлого”-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1905 онд хүрээнд “Цагдан цээрлүүлэх газар”-ыг нээн байгуулсан нь Ар Монгол дахь цагдаагийн анхны байгууллага байв. Тус цагдаагийн байгууллага нь Манж Чин Улсын хязгаар дахь орон нутгийн цагдаагийн байгууллага нь Манж Чин Улсын хязгаар дахь орон нутгийн цагдаагийн байгууллага бөгөөд манж цэрэг, монгол цагдаа нараас бүрдсэн холимог бүрэлдэхүүнтэй байснаараа онцлог юм.

1910 онд “Цагдан цээрлүүлэх газар”-ыг “Цагдан сэргийлэх цэргийн хороо” болгон өөрчилж, манж цэргүүдийг гэдрэг татан цэргийн хороонд нь буцааж, түүний оронд монгол цагдаа цэргийг ажиллуулах болсон ажээ. Шинээр байгуулагдсан “Цагдан сэргийлэх цэргийн хороо” нь хэдийгээр Манж Чин Улсын орон нутгийн цагдаагийн байгууллага байсан боловч Ар Монголд байгуулагдсан монгол цагдаа нараар бүрдсэн анхны цагдаагийн байгууллага байв.

1911 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр шашин төрийг хослон баригч 8 дугаар богд эзэн Жавзандамба хутагтыг хаанд өргөмжилснөөр Монгол Улсын хувьд төр шашин, хууль цаазын нэгэн өвөрмөц түүхэн үе эхэлсэн юм. Богд хаан төрийн таван яам байгуулсны нэг нь Жүн ван Намсрайн тэргүүлсэн Хэрэг шүүх яам ба энэ нь дотроо хэрэг бүртгэх, мөрдөн шалгах үйл ажиллагаа явуулж шүүх, ял оноох, шүүн таслах

ариутгах хэлтэстэй байжээ. Энэ үед хэргийн харьяалал, оногдуулж буй ялын хэр хэмжээг тодорхой болгож байсны баримт нь алах ялыг гагцхүү Богд хааны зарлигаар гүйцэтгэж, хошуу засаг чуулганы дарга, Ховд, Улиастай, Хиагтад суух хэрэг шийтгэх сайд төрийн зарим холбогдох яам, шүүх таслах хэргийг бүгд захиран шийтгэх сайд төрийн зарим холбогдох яам гэсэн олон шат бүхий тогтолцоог бий болгон ард иргэдэд шударга үнэний төлөө шат дараалан заргалдах эрхийг олгох болсны баримт юм.

1911 онд Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны дараа Манж Чин Улсын цагдаагийн байгууллагад ажиллаж байсан монгол цагдаа нарыг Цэргийн яамны харьяа морь цагдаа цэрэг, явган цагдаа цэрэг болгон өөрчлөн зохион байгуулснаар Монгол Улсын төрийн цагдаа анх бий болжээ.

1921 онд гадаад дотоодын эзэрхэг, түрэмгийлэгчдийг эсэргүүцсэн тэмцлийн үр дүнд ардын хувьсгал ялж, манжийн төрийн бодлогод нийцсэн байсан хуулиудыг халж жинхэнэ Монгол үндэстний хууль цаазыг зохиох ажлыг эхлүүлсэн байна.

Монголын хууль цаазын бичгүүдийн эх сурвалжийг судлан дүгнэхэд ардын хувьсгалаас өмнө гэмт хэргийг мөрдөн шалгах, түүний удирдлагын үйл ажиллагааны хэрэгжилтийн хэлбэр нь эрх зүйн зохицуулалтын хэлбэр, түүнийг хэрэгжүүлэлт зэргээс харахад орчин үеийн мөрдөх албаны зохион байгуулалтын арга, хэлбэр нь тухайн

үеийн нийгмийн хэрэгцээ шаардлага төгс биш ч тодорхой хэмжээгээр эрх зүйн зохицуулалтын хэлбэртэй байсан гэж дүгнэхэд хүргэж байна.

Ардын засгийн газрын 1921 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн хурлаар цагдан сэргийлэх байгууллагыг Цэргийн яамны бүрэлдэхүүнд оруулан, Нийслэл Хүрээг сэргийлэх цэргийн алба хаагчдаас цагдаагийн албанд татаж, “Цагдан сэргийлэх цэрэг” хэмээн нэрлэхээр тогтож, мөн өдөр “Нийслэл Хүрээний Цагдан цээрлүүлэх хороо”-г “Нийслэл Хүрээний Цагдан сэргийлэх хороо” болгож, хорооны тэмдэг, удирдах бүрэлдэхүүн, зохион байгуулалтыг өөрчлөн зохион байгуулсан. Ийнхүү Ардын Засгийн газрын Цагдан сэргийлэх байгууллага анх үүсэж байгуулагджээ.

1923 онд “Цагдан цээрлүүлснийг зөрчсөнийг яллах хууль”-ийг баталж, уг хуулиар “..Нийслэл хүрээний газар архи ууж, мөрийцөж наадах, хэрүүл шуугиан өдүүлэх, шөнийн цагт чимээ гаргах, гудамж зээлд хог буртаг орхих, гал усны аюул болгох, хулгайлах, булаах, харштай орон сав барих, гаж самуунтай тэмцэх хэргийг Цагдан сэргийлэх хороо шийдвэрлэж, эрүүгийн гэмт хэргийн шинжгүй зөрчилд захиргааны арга хэмжээ авч байхаар заасан нь мөрдөн шалгах ажиллагааг эрүүгийн хэрэг мөрдөхөд хэрэглэж байх санааг анхлан тодорхойлж байсан байна.

1924 онд Улсын анхдугаар Их Хурлаас Цагдан сэргийлэхийг Дотоод явдлын яаманд шилжүүлэн, 1926 онд Улсын цагдан сэргийлэх ерөнхий газрыг байгуулсан.

1930, 1940-өөд онд Монгол Улсын цагдан сэргийлэх байгууллагын бүтэц, зохион байгуулалт өргөжин тэлж, Улаанбаатар хот болон бүх аймгуудад цагдан сэргийлэх анги байгуулагдсанаар улсын хэмжээнд Цагдан сэргийлэх байгууллагын тогтолцоо бүрэлдэн тогтов.

Монгол Улс 1924 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр анхдугаар Үндсэн хуулиа баталж тусгаар тогтносон улс бөгөөд бүрэн эрхт, адил тэгш байдлын үндсэн дээр бусад оронтой найрсаг харилцаа тогтооход бэлэн гэдгээ дэлхий дахинаа тунхаглан зарласан. Уг Үндсэн хуульд хүний эрх, эрх чөлөөний талаар тусгахдаа “...Тус улсын иргэн угсаа гарал, яс үндэс, нас хүйс, шашин шүтлэг, хөрөнгө чинээ үл харгалзан төрийн өмнө адил тэгш эрхтэй¹ гэж хуульчилсан.

Уг үндсэн хуульд заасан “Улсын аливаа хэрэг” гэдэг нь төрийн үйл ажиллагааны бүхий л талыг хамарсан цогц ойлголт ба хууль ёсыг хангах чиг үүрэг нэгэн адил хамаарч байсан гэж үзэж болно. Уг заалтад гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, түүний удирдлагын үйл ажиллагааг шууд тодорхойлоогүй боловч агуулга, шинж байдал, хэлбэрээрээ төрийн ерөнхий чиг үүрэгт багтаж үзэхээр байна.

¹ Архивын баримт: БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн 11 дэх хэсэг.

Шинэ үндсэн хууль батлагдсанаар 1926 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр БНМАУ-ын Засгийн газрын гишүүдийн 15 дугаар хурал, Улсын бага хурлын Тэргүүлэгчдийн 21 дүгээр хурлаар “Аливаа шүүн таслах газруудыг шинэчлэн байгуулах тухай журам”-ыг баталж, Монгол Улсад анх шүүх байгуулагдсан.

1926 оны 11 дүгээр сард Улсын 3 их хурлаар БНМАУ-ын Шүүх цаазын бичиг”-ийг батлан гаргаснаар феодалын нийгмийн гэмт хэргийг хянан шалгаж байсан эрх зүйн зохицуулалтыг бүрэн халж, гэмт хэрэгтэй тэмцэх шинэ эрх зүйн үндэс бий болсон. Энэ үед гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах тусгай дагнасан байгууллага байгаагүй ба хууль ёс зөрчигчдийг илрүүлэн, түүний эсрэг тэмцэл явуулах ажиллагааг төрийн нийт байгууллага түүн дотроо шүүхийн байгууллага гүйцэтгэж байсан. Мөн 1927 онд Засгийн газар болон Улсын бага Хурлын тэргүүлэгчдээс баталсан “Монгол ард улсын ардын шүүхийн байцаагчийн түр дүрэм” байгуулагдсан аймгийн шүүхийн байцаагчаар дамжиж хэрэгжсэн. Ардын шүүхийн байцаагч нь ард иргэдийн өргөдөл гарган мэдүүлснээр өөрөө үзэж мэдснээр хууль зөрчсөн этгээдийн үйлдлийг шалгаж, тэдний хэрэг үйлдлийг бүртгэн шүүхэд шилжүүлэх, гэм буруугүй хүмүүсийг хариуцлагаас чөлөөлөх эрх, үүрэгтэйгээр ажиллаж байжээ.

1926 оны аливаа хэргийг байцаах, шүүх тухай заавар 1929 онд хууль болон боловсрогдон гарсан нь мөрдөн

шалгах ажиллагаанд шинэчлэл оруулсан байна.

Гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг цагдан сэргийлэх байгууллагын түшмэд, цагдаа нар явуулж, шүүн таслах газар, шилжүүлэн өгөх ба шүүхийн түшмэд мөрдөн байцаалтыг лавшруулан хийж, таслан шийдвэрлэдэг үйл ажиллагаа нь цагдан сэргийлэх байгууллагын дүрэм, аливаа хэргийг байцаах, шүүн таслах тухай заавар зэргийг удирдлага болгон явагддаг.

Цагдан сэргийлэх байгууллагын 1926 оны дүрмийн 29 дүгээр зүйлд “сэжиг бүхий этгээдийг дайчлан барих, нэгжих эрхтэй боловч байцаах, шийтгэх, эрхгүй болох тул тухай бүр учрыг тодорхойлон гаргаж нутгийн харъяат яам, тамгын газар явуулж гүйцэтгэн шийтгүүлбээс зохино” гэсэн бол тус хуулийн 61 дүгээр зүйлд “Аливаа хулгай, худал ба булаан авах, хүний амины хэрэг тохиолдвоос харъяат ялт хүнийг даруй түргэн байцаан барьж зохих газарт мэдүүлэн хүргэж нягтлан шийтгүүлбээс зохино” үүнээс дүгнэхэд цагдан сэргийлэх байгууллагын түшмэл, байцаагч, цагдаа нар гэмт хэргийн мэдээлэл авмагц, илэрхий хэргүүдийн гэмт этгээдүүдийг баривчлан нэгжиж, нутаг дэвсгэрийн хошуудын тамгын газрын хэрэг шийтгэх газар, шүүхийн түшмэл

байцаагч нарт шууд шилжүүлэн өгдөг эрх, үүрэгтэй байжээ¹.

Мөн хуульд “Хүнийг алсан, хүнд шархдуулсан, дутуу тахирт хүргүүлсэн зэрэг эмгэг олгосон ба хүчирхэн явалдах, насанд хүрээгүй бөгөөд бусадтай явалдаагүй охидтой явалдах, санаатайгаар гал түймэр тавих, дээрэмдэх, хулгайлсан бод мал хориос дээш ба мөнгөн зоос эд таваарын үнэ 500 төгрөгөөс дээш эдгээр эрүүгийн хэрэг болно” гэж тодорхойлсон байна.

Мөн хуульд эдгээр гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг хийж гүйцэтгэх субъектийг хуульчилж 2 дугаар зүйлийн 1-т зааснаар “ёс бус зүйлийн аливаа ихэнх эрүүгийн хэргийг шийтгэн таслахад урьдаар харьяат байцаагчид шилжүүлэн гүйцэтгүүлэх ба бусад аар саар хэргийг цагдан сэргийлэх газар байцаасныг баримтлан шийтгүүлбээс зохино². гэж заасан байдаг.

Мөн хуулийн 14 дүгээр зүйлд “Аливаа эрүүгийн хэрэг тохиолдсоны дараа цагдан сэргийлэх газраас харьяат ойр анги, байцаагч түшмэлд мэдэгдэхээс гадна түүний биеийг хүрэлцэн ирэхийн наана уг хэргийг урьдаар байцааж байвал зохино” гэж заажээ.

Дүгнэлт

Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шүүх таслахаас өмнө “байцаагч

түшмэл” албан тушаалтан гэмт хэрэгт сэжиглэгдэж буй этгээдээс биеийн байцаалт, үйлдсэн хэргийн талаар тодруулан тодорхой байцаалтыг авдаг байцаагч түшмэлд нь цагдан сэргийлэх байгууллагын ажилтнаас тусдаа өөрийн тусгайлан харьяалуулсан гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагааг явуулдаг байсан нь харагдаж байна.

Тухайн хуулиар “Байцаагч түшмэл аливаа хэргийг байцаан хянахдаа тухай бүр тогтоол байгуулж, түүнд хэрэгт холбогдсон хүмүүс: гэрчийн, байцаагдагсдын өчиг мэдүүлгийг цөс тодорхойгоор бичихээс гадна басхүү анх хэрэг халдаасан газрыг байцаан үзсэн, хэрэгт тэмдэг болох эд мөр, зэвсэг багаж юу болох орон савыг нэгжсэн зэрэг учир буй аваас бүрэн оруулж зохигчдын гарын үсэг зуруулж батлуулбаас зохино³. гэж заасныг харахад “байцаагч түшмэл” одоогийн мөрдөгчийн ажлыг гүйцэтгэж байжээ.

Ашигласан материал

1. В.В Таскин Үндэстэн улс бүрийн тухай тэмдэглэл:эмхэтгэл
2. Монголын нууц товчоо-УБ., 1990
3. И.Дашням Монгол Улсын төр, эрх зүйн түүх тэргүүн боть -УБ. 2005
4. Мөрдөн байцаах газар. Монгол улсын цагдаагийн байгууллагын мөрдөн байцаах албаны

¹ А.Думбарай. Монгол төрийн цагдаагийн уламжлал, хөгжил-УБ. 2000. 185 дахь тал

² БНМАУ-ын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг.

³ БНМАУ-ын шүүн таслах газруудад аливаа хэргийг байцаан шийтгэх тухай хуулийн 19 дүгээр зүйл

түүхэн замнал. Мөрдөн байцаах албаны
65 жилийн ойд зориулав.-УБ 2011

5. Г.Совд БНМАУ-ын Эрүүгийн
эрхийн курс.- УБ. 1973.

6. Т.Алтангэрэл. Монгол-
Ойрадын их цааз түүний судалгаа-УБ.
1998

7. Архивын баримт:БНМАУ-ын
анхдугаар Үндсэн хууль

8. А.Думбарай. Монгол төрийн
цагдаагийн уламжлал, хөгжил-УБ.
2000.

9. БНМАУ-ын шүүн таслах
газруудад аливаа хэргийг байцаан
шийтгэх тухай хууль